



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтдаг мэдээлэл технологийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна. Мөн АНУ-ын газрын тосны нөөц багасч, газрын тосны үнэ өссөнөөр эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш өсжээ.

АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар эмийн сангуудад хөнгөлөлт үзүүлэх эрүүл мэндийн хөтөлбөрөө зогсоохоор шийдвэрлэж, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьцааны ханш өссөн бол эм үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байв.

Энэ сарын 30-31-ны өдрүүдэд болох мөнгөний бодлогын хуралдаанаар Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ бууруулна гэсэн хүлээлт хөрөнгө оруулагчдын дунд давамгайлсаар байна.

Европ: Европын төв банк болоод Холбооны нөөцийн сан мөнгөний бодлогоо зөөлрүүлэх хандлагатай байгааг үл харгалзан Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд буурч хаагдлаа.

Франц улсын Сенат гадаадын технологийн компаниудад цахим татвар ногдуулснаар Франц улс АНУ-ын худалдааны хориг арга хэмжээний дараагийн бай боллоо. Францад технологийн томоохон 30 компани үйл ажиллагаа явуулдагаас дийлэнх нь АНУ-ын компаниуд юм. Тус улсын Сенат Францад үйл ажиллагаа явуулж буй мэдээлэл технологийн компаниудын ашигт 3 хувийн татвар ногдуулах шийдвэр гаргасан байна.

Европын комисс Европын бүс нутгийн эдийн засгийн өсөлт болоод инфляцийн түвшний таамгаа буурууллаа. Тус байгууллага нь үүнийгээ АНУ-ын худалдааны бодлогын тодорхойгүй байдалтай холбон тайлбарласан байна. Инфляцийн түвшинг 2 орчим хувь байна хэмээн таамаглаж байгаа бол эдийн засгийн өсөлтийг 2018 онд 1.9%-аас 1.2%, 2020 онд 1.5%-аас 1.4% болгон тус тус бууруулжээ.

БНХАУ: Хятадын эдийн засаг энэ оны 2-р улиралд 1992 оноос хойшхи хамгийн сул өсөлтийг үзүүллээ.

Тус улсын Статистикийн Үндэсний хорооноос мэдээлснээр БНХАУ-ын ДНБ 2019 оны 4-р сараас 6-р сарын хугацаанд 6.2 хувиар өссөн ажээ. Үүнийг өмнөх улирлынхтай харьцуулахад 0.2 хувиар буурсны зэрэгцээ өнгөрсөн оны 4-р улирлаас хойшхи анхны буурсан үзүүлэлт болжээ.

“Санхүүгийн хүндрэлийн улмаас орон нутгийн засаг захиргаад дэд бүтцийн зардлаа танаж байна” гэж эдийн засагчид мэдээлсэн бөгөөд тэдний үзэж буйгаар, АНУ-ын импортын хэмжээ ихээхэн буурсан нь үйлдвэрлэл болон тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг сааруулсан ажээ.

Хятад улс энэ онд эдийн засгийн өсөлтөө 6-6.5 хувь хүрнэ хэмээн урьдчилсан таамаглаж байгаа хэдий ч цаашид энэ үзүүлэлт суларсан хэвээр байвал нэмэлт арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэх шаардлага тулгарна хэмээн ажиглагчид үзэж байна.

Эх сурвалж: Troweprice.com, Montsame.mn

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,718.12	-0.03% ▼
Dow Jones	АНУ	27,332.03	1.52% ▲
S&P 500	АНУ	3,013.77	0.78% ▲
Nasdaq	АНУ	8,244.14	1.01% ▲
S&P/TSX	Канад	16,488.12	-0.33% ▼
FTSE 100	Их Британи	7,505.97	-0.62% ▼
S&P/ASX 200	Австрали	6,653.00	-0.48% ▼
Nikkei 225	Япон	21,685.90	-0.36% ▼
Hang Seng	Хонг Конг	28,554.88	-0.76% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.56
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.20
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	101.14
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.04
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.89
DBM' 2023	USD	7.250%	104.80
TDBM' 2020	USD	9.375%	103.65

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.330	-0.04 ▼
Libor 3M	2.320	0.01 ▲
Libor 6M	2.230	0.02 ▲
Libor 1YR	2.230	0.04 ▲
US 2YR Bond	1.842	0.00
US 3YR Bond	1.817	0.02 ▲
US 5YR Bond	1.854	0.04 ▲
US 10YR Bond	2.094	0.07 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.07.12	Өөрчлөлт
USD	2,659.50	0.03% ▲
CNY	386.31	-0.05% ▼
EUR	2,982.50	-0.44% ▼
RUB	41.69	-0.29% ▼
KRW	2.25	-0.88% ▼
JPY	24.41	-0.77% ▼
CAD	2,025.05	-0.48% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,415.75	1.16% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	15.22	1.47% ▲
Зэс	USD/lb.	269.40	1.24% ▲
Нүүрс	USD/MT	75.43	-2.19% ▼
WTI газрын тос	USD/bbl.	60.21	4.69% ▲
Brent газрын тос	USD/bbl.	66.72	3.88% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.45	1.24% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. V	7.90%
Бодлогын хүү	2019. V	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. V	11.03%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. V	11.60%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. V	4.93%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. V	17.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. V	10.60%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 38 компанийн 7,533.2 сая төгрөгийн 437,500 ширхэг хувьцаа арилжигдав.

“Улаанбаатар хивс” /UBH/ компанийн хувьцаа 48.39%-аар буюу хамгийн ихээр өсөж 23,000 төгрөгт хүрч хаагдсан бол “ор” /SOR/ компанийн хувьцаа 14.71%-аар буурч 980 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


7-р сарын 12-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,598.1 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,718.12 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.03%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	7,533.18
Зах зээлийн үнэлгээ	2,598,058

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,718.12	-0.03% ▼
MSE I индекс	9,681.60	-0.58% ▼
MSE II индекс	8,121.73	0.76% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
МИК Холдинг	437,500	7,000,000,000
Улаанбаатар хивс	11,456	263,126,380
Монгол шуудан хк	100,316	61,094,418
Монгол базальт хк	143,877	44,095,747
Таван толгой	5,243	38,599,130

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Улаанбаатар хивс	23,000.00	48.39% ▲
Могойн гол	8,000.00	21.21% ▲
Хүннү менежмент	427.89	15.00% ▲
Эрдэнэ ресурс девелопмент	488.00	8.68% ▲
Хөвсгөл алтан дуулга	706.00	5.09% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Сор	980.00	-14.71% ▼
Гермес центр	125.00	-10.59% ▼
Монгол савхи	600.00	-7.69% ▼
Адуун чулуу	1,601.00	-5.27% ▼
Мандал даатгал	5,145.00	-3.83% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ти Ди Би Капитал	14,031,908,968
Тулгат чандмань баян	269,867,720
Дэлгэрхангай секюритиз	262,289,100
Гаули	207,822,190
Голомт Капитал	55,536,210

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	571.01	607,658
Таван толгой	7,395.00	389,459
МИК Холдинг	14,500.00	300,285
Говь	292.30	228,027
Инвескор ББСБ	1,799.00	129,039

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

СЗХ-ны 2019 оны ээлжит XI хуралдаан болж нийт 30 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны ээлжит XI хуралдаан 7 дугаар сарын 8-ны өдөр болж нийт 30 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хуралдаанаар “Мөнх даатгал” ХХК-ийн 8 салбарыг, “Хас-Үнэлгээ” ХХК-ийн төлөөлөгчийн газрыг бүртгэж, нэр бүхий 22 иргэнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 6 иргэний тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, “Тэнгэр даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрөв.

Мөн “Трасс Чэйн менежмент” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “Домикс сек” ХХК-д үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “МИК актив хорь” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олголоо.

“МИК актив хорь” ХХК-ийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг, “Үндэсний хувьчлалын сан” хаалттай, хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэн авч, “Блэкстоун интернэйшнл ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах, “Санар ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирлыг томилохыг зөвшөөрөв.

Хуралдаанаар “Хавцалын боом” хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, “Ноён даамал”, “Монсант алдар”, “БЭХ”, “Кредит-Юнион монгол”, “Мина” ХЗХ-дын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгалаа.

“Эрин финанс” ХХК-д банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, “Би энд Жи финанс ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгохыг зөвшөөрөв.

Харин “Таван ханхар”, “Хужиртайн булгийн ундарга”, “Субуд”, “Өнөр их наяд” ХЗХ-дын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо.

“Би эй ди эй би ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээж, “Прайм файнаншиал холдингс ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, “Улам хөгжих ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов.

Мөн салбарын үйл ажиллагаатай холбоотой зарим журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн дахин хэлэлцэн батлалаа.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



МХБ дээр 7 тэрбум төгрөгийн багцын арилжаа явлаа

2019 оны 7 сарын 10-ны өдөр “МИК Холдинг” ХК-ийн /MSE:MIK/ багцын арилжаа явагдлаа. Багцын арилжаагаар тус компанийн 437,500 ширхэг хувьцаа 7 тэрбум төгрөгөөр арилжигджээ.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК ХХК

Хамтын хөрөнгө оруулалтын сан ажиллах боломж бүрдэнэ

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлд олон шинэ үнэт цаас амжилттай гарч, хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэж, зах зээл идэвхжихийн хирээр зах зээлийн хөрвөх чадварыг хангах, тогтвортой байдлыг бий болгох асуудал тулгамдаж байгаа бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх шаардлага үүсээд байна.

Мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хөрөнгө оруулалтын сангуудын оролцоог нэмэгдүүлэхийн тулд тэдгээрийн нэгж эрхийг Бирж бүртгэж, арилжааг зохион байгуулснаар хөрөнгө оруулагчид биржээр дамжуулан хамтын хөрөнгө оруулалтын сангуудад хөрөнгө оруулж, оновчтой удирдлагаар хангагдах давуу талтай юм. Иймд МХБ-ээс “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын төслийг боловсруулж, 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Хороо, “АТТ” ХХК, МҮЦАЭХ, үнэт цаасны гишүүн компаниуд, хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, дээрх байгууллагуудын саналыг бичгээр авч төсөлд тусгасан.

Түүнчлэн, журмын төслийг сар гарангийн хугацаанд өөрийн цахим хуудаст байршуулж, олон нийт, зах зээл сонирхогчид, судлаачдын саналыг авч тусгасны үндсэн дээр журмын төслийг эцэслэн боловсруулж МХБ-ийн ТУЗ-ийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 тоот тогтоолоор батлуулан, Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулахаар хүргүүлээ.

Уг журмыг Хороо батламжилснаар хүчин төгөлдөр мөрдөгдөх юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эрдэнэ Ресурс: Хаалттай хүрээнд 2.0 сая канад доллар босголоо

Монголын Хөрөнгийн Бирж болон Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Эрдэнэ ресурс девелопмент корпораци /MSE:ERDN/ компани хаалттай хүрээнд хөрөнгө оруулалт босгохоор ажиллаж байгаа талаар мэдээлж байсан.

Тэгвэл, компани хөрөнгө оруулагчдаас 2 сая кан.доллар амжилттай босгосон тухайгаа албан ёсоор мэдэгдлээ. Тодруулбал, Эрдэнэ Ресурс /MSE:ERDN/ нь нэг бүр нь 0.20 кан. долларын үнэтэй 10,007,500 ширхэг үнэт цаас худалдсан байна.

Уг хөрөнгө оруулалтыг Хөндий алтны төслийн хараат бус урьдчилсан ТЭЗҮ боловсруулах, Баян Хөндийн хүдрийн биетийн тэлэлтийн бүсийн үргэлжлэлийг шалгах өрөмдлөгийн хөтөлбөр, төслийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл, худалдан авалт болон эргэлтийн хөрөнгөд зарцуулах аж.

Нэмж хэлэхэд Эрдэнэ Ресурс /MSE:ERDN/ компани өнгөрөгч 3-р сард мөн 2.5 сая кан.долларыг хөрөнгө оруулагчдаас босгож байсан бөгөөд ийнхүү 2019 он гарснаас хойш 2 дахь удаагаа хаалттай санхүүжилт татлаа.

Хувьцааны ханшийн тухайд дотоодын хөрөнгийн бирж дээр 2018 онд давхар бүртгэгдснээс хойш 23.8%-иар унаж 488 төгрөгийн ханштай байгаа юм.

Эх сурвалж: MarketInfo.mn

БУСАД МЭДЭЭ

Фитч агентлаг Монгол улсын зээлжих зэрэглэлийг хэвээр үлдээв

Фитч (Fitch) агентлаг нь 2019 оны 7 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийг “В”, төлөвийг “Тогтвортой” хэвээр, богино хугацааны зээлжих зэрэглэлийг “В” хэвээр үлдээсэн байна.

Фитч агентлагаас Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг “В” хэвээр үлдээхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Эдийн засгийн өсөлтийн тогтвортой төлөв, төсвийн болон засаглалын үзүүлэлтүүд сайжирч буй нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээнд эерэгээр нөлөөлөв. Гэвч Монгол Улс эдийн засгийн хязгаарлагдмал суурьтай, гадаад нөөцийн хамгаалалт (buffer) хангалтгүй, улс төрийн тогтворгүй байдал нь эдийн засгийн бодлогод огцом өөрчлөлт оруулах нөхцөл байдлыг үүсгэх, эдийн засагт шок учрах магадлалыг нэмэгдүүлэх эрсдэлтэй тул зээлжих зэрэглэлийн үнэлгээг дээшлүүлэхэд хязгаарлалт болсон байна.
- Төсвийн ашиг 2018 онд ДНБ-ий 2.6 хувьд хүрч, батлагдсан төсөв болон Фитч агентлагийн төсөөлсөн дүнгээс давсан байна. Орлогыг нэмэгдүүлэх чиглэлд шинээр арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй хэдий ч 2019 оны 5 дугаар сарын төслийн гүйцэтгэлийн мэдээгээр төсвийн орлого болон зардал тогтвортой өссөн байна. 2020 оны УИХ-ын сонгуулийг урьтаж төсвийн зарлага огцом өсөөд байгаа бөгөөд өнөөгийн төсвийн сайн гүйцэтгэл ирэх онд үргэлжлэх эсэх нь тодорхойгүй байна. Тус агентлагийн үзэж байгаагаар Монгол Улсын төсвийн алдагдал 2020 онд 4 хувьд (эрх бүхий байгууллагын төсөөлснөөс 2 нэгж хувиар өндөр) хүрэхээр байна. Иймд Фитч агентлагын суурь төсөөлөлд улс төрийн циклээс шалтгаалсан эрсдэлүүд ихээхэн нөлөө үзүүлэх хүлээлттэй байна.
- Төсвийн гүйцэтгэл сайжирч, эдийн засгийн сэргэлт үргэлжилснээр Засгийн газрын нийт өр (GGGD) огцом буураад байна. Фитч агентлагийн суурь төсөөллөөр 2019 оны эцэст Засгийн газрын өр ба ДНБ-ий харьцаа 60 хувьд хүрч буурах, Монгол Улсын өр 2020 оноос эхлэн алгуур буурах хандлагатай байна. Гэвч төсвийн алдагдал өндөр байхаар хүлээгдэж буй тул Монгол Улсын Засгийн газрын өр ба ДНБ-ий харьцаа “В” зээлжих зэрэглэл бүхий улс орнуудын медиан (49 хувь)-аас их байх таамагтай байгаа юм.
- ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хийгдсэн Активын чанарын үнэлгээ (AQR)-тэй холбоотой хоёр урьдач ажил хийгдэж дуусаагүй байгаагаас шалтгаалан ОУВС-гаас хөтөлбөрийн 6 дахь шатны үнэлгээг хараахан дүгнээгүй байна. 2019 оны 6 дугаар сард ОУВС-гийн ажлын хэсэг дүрмийн IV заалтын зөвлөлдөх яриа хэлэлцээний талаар хэвлэлийн мэдэгдэл гаргасан. Уг хэвлэлийн мэдэгдэлд Монгол Улс эдийн засгийн дархлааг сайжруулах чиглэлд тодорхой ахиц гаргасан боловч ирээдүйд учирч болзошгүй гадаад шокуудыг даван туулахад шаардлагатай нөөцийн хамгаалалт хангалтгүй хэвээр байгааг онцолсон байна.

- Үүний зэрэгцээ эрх баригчдын зүгээс шаардлагатай урьдач арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, тухайлбал активын чанарын үнэлгээний хүрээнд банкуудын нэмэгдүүлсэн өөрийн хөрөнгөд магадлан шалгалт хийлгэх төлөвлөгөөтэй байгаагаа илэрхийлсэн. Холбогдох арга хэмжээнүүдийг амжилттай хэрэгжүүлснээр ОУВС-гаас болон донор орнуудаас нэмэлт санхүүжилт татах нөхцөл бүрдэнэ.
- Банкны салбарын активын чанар сул хэвээр буюу салбарын чанаргүй зээлийн харьцаа 2019 оны 5 дугаар сарын эцсийн байдлаар 11 хувьтай байгаа бөгөөд зарим банкуудын удаан хугацаанд бүртгэгдэж ирсэн зээлүүдийн чанар муудсаар байна. Гэхдээ 2019 оны 4 дүгээр сард Капитал банкны татан буулгах шийдвэр гаргасан нь санхүүгийн салбарт бүтцийн сайжруулалт хийх үүрэг, амлалтаа үргэлжлүүлж байгаагийн илрэл гэж тус агентлагаас үзэж байна. Үргэлжлэн хийгдэж буй Активын чанарын үнэлгээний үр дүнд зарим банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагатай хэвээр эсвэл татан буулгаж ч болзошгүй. Гэвч Фитч агентлагаас энэ нь эцсийн дүндээ банкны системийг бэхжүүлэх ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн чухал зорилт гэж үзэж байна. Системийн ач холбогдолтой банкуудын өөрийн хөрөнгийн дутагдлыг хангахад төрөөс санхүүжүүлэх боломжтой ч энэ нь Активын чанарын өмнөх үнэлгээгээр ДНБ-ий 1.9 хувийн өөрийн хөрөнгийн дутагдалтайг мэдээлэх үеийн тус Агентлагийн зээлжих зэрэглэлийн үнэлгээнд нөлөөлнө гэж үзэхгүй байна.
- Бүтцийн хүчин зүйлсүүд, тухайлбал нэг хүнд ногдох ДНБ, засаглалын шалгуур үзүүлэлтүүд, бизнес эрхлэхэд таатай байдлын онооны хувьд “В” зээлжих зэрэглэл бүхий орнуудтай харьцуулахад өндөр үнэлгээ авсан бөгөөд эдгээр нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээнд ихээхэн дэмжлэг үзүүлж байна гэж тус агентлаг дурдсан байна.

Цаашид Монгол улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйлс:

- Засгийн газрын өр, ДНБ-ий харьцааны бууралттай уялдаатайгаар төсвийн алдагдлын хэмжээ буурах;
- Найдвартай болон харилцан уялдаатай макро эдийн засгийн бодлогуудыг тогтвортой хэрэгжүүлэх, улмаар түүхий эдийн үнэ болон гадаад орчны савлагаанаас хамаарсан эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах;
- Эдийн засгийн тогтвортой өсөлт болон ГШХО-ын орох урсгалыг дэмжсэн бизнесийн орчныг хадгалах.

Зээлжих зэрэглэлийг бууруулахад нөлөөлөх хүчин зүйлс:

- ГШХО-ын орох урсгал болон уул уурхайн төслүүдийг тасалдуулах эрсдэл бүхий улс төрийн тогтворгүй байдал үүсэх;
- Засгийн газрын өр ба ДНБ-ий харьцааг буцаан өсгөх төсвийн бодлого баримтлах.

Эх сурвалж: Монголбанк

мэдэгдэл

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.